

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-/215/2023-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbataart@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.14 № 01/45
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН
САНГИЙН ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ЗОРИГТБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Нийтийн номын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Нийтийн номын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Нийтийн номын сан нь тайлант оноос эхлэн орон нутгаас 37.5 хувийн, улсын төсвөөс 62.5 хувийн санхүүжилт авч тайлагнадаг соёлын яамны харьяа байгууллага болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Сургалтын танхим түрээслүүлсний болон үйл ажиллагааны орлогыг аккрузал сууриар бүртгэдэггүй байна.
- Бэлэн мөнгө, кассын бүртгэл, тайлагнал хангалтгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,763,399.00	22,399,569.07
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	9,001,530.07
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	9,001,530.07
3121	Төгрөг	00.00	9,001,530.07
31211	Төрийн сангийн харилцах	00.00	9,001,530.07
35	БАРАА МАТЕРИАЛ	9,763,399.00	13,398,039.00
354	Хангамжийн материал	9,763,399.00	13,398,039.00
35410	Бичиг хэргийн материал	148,400.00	242,400.00
35420	Аж ахуйн материал	9,554,999.00	13,155,639.00
35440	Түлш, шатах тослох материал	60,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,187,193,060.34	2,134,472,965.98
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,187,193,060.34	2,134,472,965.98
392	Биет хөрөнгө	2,153,409,302.27	2,100,369,209.19
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,901,075,852.00	1,901,075,852.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-45,660,110.76	-82,499,789.88
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,500,000.00	21,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-21,500,000.00	-21,500,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	88,729,691.37	88,729,691.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	-18,462,819.82	-31,904,089.73
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	152,152,010.81	152,791,910.81
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,847,106.11	-29,905,445.36
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,209,773.09	2,209,773.09
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,054,622.97	-2,145,527.77
39217	Ном	90,266,634.66	102,016,834.66
393	Биет бус хөрөнгө	33,783,758.07	34,103,756.79
39301	Програм хангамж	4,930,000.00	6,430,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,696,249.93	-4,751,249.89
39303	Бусад биет бус хөрөнгө	33,550,008.00	33,550,008.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-1,125,001.32
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,196,956,459.34	2,156,872,535.05
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	7,325,895.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	7,325,895.00
413	Өглөг	00.00	7,325,895.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	7,325,895.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,196,956,459.34	2,149,546,640.05
51	Засгийн газрын хувь оролцоо	2,196,956,459.34	2,149,546,640.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	374,082,784.22	374,082,784.22
51101	Өмч: - төрийн	374,082,784.22	374,082,784.22
512	Хуримтлагдсан үр дүн	1,103,052,577.21	1,055,642,757.92

51210	Өмнөх үеийн үр дүн	1,103,052,577.21	1,103,052,577.21
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-47,409,819.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	719,821,097.91	719,821,097.91
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,196,956,459.34</u>	<u>2,156,872,535.05</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,606,174,574.50	310,800,635.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,360,642,674.50	6,252,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,360,642,674.50	6,252,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,352,784,474.50	6,002,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,188,700.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,352,784,474.50	2,813,800.00
120009	Бусад орлого	7,858,200.00	250,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	245,531,900.00	304,548,135.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	176,337,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	176,337,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	14,750,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	14,750,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	245,531,900.00	113,460,635.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	245,531,900.00	113,460,635.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	271,713,019.48	358,210,454.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	271,713,019.48	358,210,454.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	271,296,319.48	354,841,869.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,010,088.35	136,409,539.22
210101	Үндсэн цалин	90,312,307.40	110,029,542.50
210102	Нэмэгдэл	26,287,780.95	16,492,464.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,410,000.00	8,229,000.00
210104	Урамшуулал	00.00	1,658,532.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,844,025.61	17,091,643.73
210201	Тэтгэврийн даатгал	12,020,475.92	11,665,275.35
210202	Тэтгэмжийн даатгал	1,340,900.94	1,372,385.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	992,080.77	1,091,188.30
210204	Ажилгүйдлийн даатгал	226,415.18	269,344.86
210205	Эрүүл мэндийн даатгал	2,264,152.80	2,693,449.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,823,126.00	102,604,795.00
210301	Гэрэл, цахилгаан	3,147,804.00	5,606,025.00
210302	Түлш, халаалт	87,744,888.00	94,690,043.00
210303	Цэвэр, бохир ус	1,930,434.00	2,308,727.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,233,808.75	3,929,866.84
210401	Бичиг хэрэг	1,507,500.00	954,750.00
210402	Тээвэр, шатахуун	925,000.00	581,132.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,345,718.75	1,541,744.84
210404	Ном, хэвлэл	347,100.00	701,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	108,490.00	150,840.00

2105	Нормативт зардал	542,820.00	300,250.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	542,820.00	300,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,559,370.00	1,060,950.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	618,100.00
210604	Урсгал засвар	3,559,370.00	442,850.00
2107	Томилолт, зочны зардал	248,000.00	212,000.00
210702	Дотоод албан томилолт	248,000.00	212,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,121,620.00	19,243,420.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	804,500.00	19,243,420.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	133,620.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,859,500.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,913,460.77	73,989,404.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,000.00	7,379,210.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,742,009.48	66,610,194.36
210904	Найдваргүй авлагын алдагдал	4,107,451.29	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	416,700.00	3,368,585.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	416,700.00	840,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	416,700.00	840,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,907,752.58
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,907,752.58
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	620,832.56
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	620,832.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,334,461,555.02	-47,409,819.29
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,334,461,555.02	-47,409,819.29

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	253,390,100.00	307,986,835.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,858,200.00	3,438,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,858,200.00	3,438,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	3,188,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,188,700.00
120009	Бусад орлого	7,858,200.00	250,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	245,531,900.00	304,548,135.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	176,337,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	176,337,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	14,750,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	14,750,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	245,531,900.00	113,460,635.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	245,531,900.00	113,460,635.00

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	253,390,100.00	287,909,004.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	253,390,100.00	287,909,004.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	248,865,948.71	284,620,419.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,010,088.35	136,409,539.22
210101	Үндсэн цалин	90,312,307.40	110,029,542.50
210102	Нэмэгдэл	26,287,780.95	16,492,464.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,410,000.00	8,229,000.00
210104	Урамшуулал	00.00	1,658,532.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,844,025.61	17,091,643.73
210201	Тэтгэврийн даатгал	12,020,475.92	11,665,275.35
210202	Тэтгэмжийн даатгал	1,340,900.94	1,372,385.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	992,080.77	1,091,188.30
210204	Ажилгүйдлийн даатгал	226,415.18	269,344.86
210205	Эрүүл мэндийн даатгал	2,264,152.80	2,693,449.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,823,126.00	95,278,900.00
210301	Гэрэл, цахилгаан	3,147,804.00	5,606,025.00
210302	Түлш, халаалт	87,744,888.00	87,364,148.00
210303	Цэвэр, бохир ус	1,930,434.00	2,308,727.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,141,788.75	3,925,116.84
210401	Бичиг хэрэг	989,170.00	989,750.00
210402	Тээвэр, шатахуун	545,000.00	521,132.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,550,918.75	1,541,744.84
210404	Ном, хэвлэл	2,702,900.00	701,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,353,800.00	171,090.00
2105	Нормативт зардал	300,000.00	300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,894,570.00	1,346,350.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	846,350.00
210604	Урсгал засвар	3,894,570.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	248,000.00	212,000.00
210702	Дотоод албан томилолт	248,000.00	212,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,179,350.00	21,612,420.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	805,230.00	21,612,420.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	187,120.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,863,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	425,000.00	8,444,450.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	425,000.00	8,444,450.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,524,151.29	3,288,585.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	416,700.00	760,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	416,700.00	760,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,107,451.29	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,107,451.29	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,907,752.58
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,907,752.58
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	620,832.56
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	620,832.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	20,077,830.07

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	11,076,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	11,076,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	11,076,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	11,076,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-11,076,300.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	9,001,530.07
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	9,001,530.07

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	347,282,784.22	378,194,572.06	-216,195,080.33	00.00	509,282,275.95
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	347,282,784.22	378,194,572.06	-216,195,080.33	00.00	509,282,275.95
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-11,688,330.72	00.00	-11,688,330.72
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	374,082,784.22	719,821,097.91	1,103,052,577.21	00.00	2,196,956,459.34
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	374,082,784.22	719,821,097.91	1,103,052,577.21	00.00	2,196,956,459.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	374,082,784.22	719,821,097.91	1,103,052,577.21	00.00	2,196,956,459.34
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-47,409,819.29	00.00	-47,409,819.29
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	374,082,784.22	719,821,097.91	1,055,642,757.92	00.00	2,149,546,640.05

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	302,961,800.00	288,557,517.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	302,961,800.00	288,557,517.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	302,193,800.00	287,797,517.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	137,751,300.00	129,977,403.22
210101	Үндсэн цалин	60,451,800.00	103,597,406.50
210102	Нэмэгдэл	27,969,600.00	16,492,464.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,072,000.00	8,229,000.00
210104	Урамшуулал	40,257,900.00	1,658,532.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,219,000.00	16,287,627.29
210201	Тэтгэврийн даатгал	11,708,900.00	11,118,544.37
210202	Тэтгэмжийн даатгал	1,377,400.00	1,308,064.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,102,000.00	1,039,731.22
210204	Ажилгүйдлийн даатгал	275,600.00	256,480.60
210205	Эрүүл мэндийн даатгал	2,755,100.00	2,564,807.04

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,278,900.00	95,278,900.00
210301	Гэрэл, цахилгаан	4,033,300.00	5,606,025.00
210302	Түлш, халаалт	87,745,600.00	87,364,148.00
210303	Цэвэр, бохир ус	3,500,000.00	2,308,727.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,810,700.00	12,800,216.84
210401	Бичиг хэрэг	650,000.00	928,450.00
210402	Тээвэр, шатахуун	400,000.00	521,132.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,810,700.00	1,541,744.84
210404	Ном, хэвлэл	9,750,000.00	9,637,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	200,000.00	171,090.00
2105	Нормативт зардал	300,000.00	300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	1,346,350.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00	846,350.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	259,700.00	212,000.00
210702	Дотоод албан томилолт	259,700.00	212,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,754,200.00	22,638,420.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,754,200.00	22,638,420.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,820,000.00	8,956,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,820,000.00	8,956,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	768,000.00	760,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	768,000.00	760,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	760,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	302,961,800.00	301,054,047.42
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	176,337,500.00	176,337,500.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	176,337,500.00	176,337,500.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	105,620,100.00	103,712,347.42
320001	Орон нутгийн төсвөөс	105,620,100.00	103,712,347.42
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	21,004,200.00	21,004,200.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,254,200.00	6,254,200.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,750,000.00	14,750,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0.00	9,001,530.07
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	12.00	12.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	6.00	6.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,899,202.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,899,202.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,899,202.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,432,136.00
210101	Үндсэн цалин	6,432,136.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	804,016.44
210201	Тэтгэврийн даатгал	546,730.98
210202	Тэтгэмжийн даатгал	64,321.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	51,457.08
210204	Ажилгүйдлийн даатгал	12,864.26
210205	Эрүүл мэндийн даатгал	128,642.74
2104	Хангамж, бараа материалын зардал	61,300.00
210401	Бичиг хэрэг	61,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	474,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	474,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	127,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	127,750.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	620,797.56
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,520,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,520,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,840,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	679,500.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Нийтийн номын сан нь “Мэдлэг оюунд тулгуурласан мэдээллийн эрин зуунд дэвшилтэд техник технологийг ашиглан уншигч, үйлчлүүлэгчдэд хэрэгцээт мэдээллийг нээлттэй хүргэх” үйл ажиллагаа явуулдаг, соёлын яамны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь нийтийн номын санг шинэ тоног төхөөрөмжөөр хангах, цахим мэдээллийн үйлчилгээг өргөжүүлэх, иргэдийг соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулах, сан хөмрөгийн цахим номын тоог нэмэгдүүлж унших боломжоор хангах зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Төв аймгийн Нийтийн номын сан нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, хэрэгжүүлэх 53 арга хэмжээтэй баталснаас нийт 94.0%-тай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Нийтийн номын сан нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Номын сангийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

Төв аймгийн Нийтийн номын сангийн дотоод хяналтын ажлын хэсэг нь 3 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд тайлант онд 9 ажил төлөвлөж, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Нийтийн номын санд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албаас хяналт шалгалт хийгдсэн байна. Шалгалтаар 500.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоогдсон байна.

Төв аймгийн Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Нийтийн номын сан нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын даргын даргын 2019 оны 12 дугаар сарын 24-ний А/21 дүгээр тушаалаар батлагдсан шинэчилсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Нийтийн номын сан нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40,083.9 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	9,001.5	9,001.5
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	9,763.4	13,398.0	3,634.6
Үндсэн хөрөнгө	2,187,193.0	2,134,472.9	-52,720.1
Нийт хөрөнгө	2,196,956.4	2,156,782.5	-40,083.9
Өр төлбөр	0.0	7,325.9	7,325.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,196,956.4	2,149,546.6	-47,409.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,196,956.4	2,156,782.5	-40,083.9

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд улсын төсвийн санхүүжилтийн дансны үлдэгдэл 9,001.5 мянган төгрөг оны эцэст татагдаагүйгээс мөнгөн хөрөнгийн данс эцсийн үлдэгдэлтэй тайлагнагдан байна. Бараа материал дансны эхний үлдэгдэл 9,763.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 13,398.0 мянган төгрөг болж нэмэгдсэн болон хасагдсан бараа материалын зөрүү 3,634.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 2,187,193.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 2,134,472.9 мянган төгрөг болж, 40,083.9 мянган төгрөгөөр буурсан нь нэмэгдсэн болон хасагдсан үндсэн хөрөнгөөс гадна элэгдлийн зардалтай холбоотой байна. Хандиваар 2,813.8 мянган төгрөгийн ном хүлээн авсан байна.

Өглөгийн данс 7,325.9 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй болсон нь орон нутгаас түлш халаалтын зардлын төсвийг батлахдаа дутуу баталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,149,546.6 мянган төгрөг болж 47,409.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 373,793.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Нийтийн номын сангаас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 142,410.9 мянган төгрөгөөр бууруулан 2022 оны урсгал зардлын төсвийг орон нутгаас 105,620.1 мянган төгрөг, улсын төсвөөс 125,762.2 мянган төгрөг, нийт 231,382.3 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн.

Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл тухайн байгууллагын төсвийн төсөлд хүргүүлсэн саналд үндэслэлгүй баталдгаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 231,382.3 мянган төгрөгт 1 удаа тодотгол хийж 288,024.6 мянган төгрөг болсон ба 281,957.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 176,337.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 105,620.1 мянган төгрөг, оны дундуур соёлын яамнаас 10,000.0 мянган төгрөг, аймгийн Боловсрол соёлын газраас 4,750.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 6,254.2 мянган төгрөг, нийт 302,961.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 1,907.7 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 288,557.5 мянган төгрөг буюу 95.2 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлуудыг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71702/80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	165,569.5	158,023.5	7,546.0	95.4%
2	71702/80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	10,000.0	8,907.3	1,092.7	89.0%
3	71702/80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	768.0	760.0	8.0	98.9%
4	71702/83603 Дээд шатны төсвөөс хуваарилсан арга хэмжээ	17,509.2	17,154.2	355.0	97.9%
5	71702/80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	95,778.9	95,778.9	0.0	100.0%
6	71702/80112 Нийтлэг үйлчилгээ	13,336.2	7,933.4	5,402.8	59.5%
	ДҮН	302,961.8	288,557.5	14,404.3	95.2%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Нийтийн номын сангийн нэмэлт санхүүжилтийн дансанд уншигчийн картын орлого, сургалтын заалны түрээсийн орлого 679.5 мянган төгрөг, орон нутгаас олгосон нийтлэг үйлчилгээний албан хаагчдын цалингийн санхүүжилт 7,840.5 мянган төгрөг, нийт 8,520.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Нийтийн номын сан нь тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар цалин нийгмийн даатгалын шимтгэлд 7,236.1 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 61.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 601.7 мянган төгрөг нийт 7,899.2 мянган төгрөг зарцуулж 620.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71702	2022.01.01-2022.12.31	Соёл урлаг	Хөтөлбөр 94.0 %	302,961.8	288,557.5

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Нийтийн номын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Улсын ерөнхий Нийтийн номын сангийн 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Нийтийн номын сангийн батлагдсан 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,606,224.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 24,093.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 18,070.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Нийтийн номын санд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Нийтийн номын сангийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад мэдээлбэл зохих 167 мэдээллээс 11 мэдээлэл хугацаа хоцроосон, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 9 шийдвэрийг мэдээлээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Нийтийн номын сангийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 4 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 3 зөвлөмж нь хэрэгжээгүй тул аудитын тайланд тусгаж зөрчлөөр оруулсан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн 3 зөвлөмж, 1 албан шаардлага өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	2,858.0	1	2,858.0	100
Зөвлөмж	3	16,184.4	3	16,184.4	100
Нийт дүн	4	19,042.4	4	19,042.4	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Нийтийн номын сангийн дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 34,080.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 34,080.5 мянган төгрөгийн алдааг залрууллаа.Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг үр дүнгийн тайланд 34,080.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 12,490.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 12,490.0 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг цахим төлбөрийн баримттай тулгалт хийхэд цахим төлбөрийн баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 12,490.0 мянган төгрөгөөр дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-ын 6.5-д Төлбөрийн баримт “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, санхүүгийн тайлангийн аудитын “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Цаашид худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулах, худалдан авах гэрээнд цахим төлбөрийн баримт авах талаар тусгах, тухай бүр хяналт тавьж байх.

2. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сургалтын заалыг түрээслэхдээ гэрээ байгуулдаггүй, гэрээний дагуу орлогыг аккрузал сууриар бүртгэж авлага үүсгэдэггүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид түрээсийн орлогын гэрээ байгуулж авлага үүсгэж ажиллах.

3. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Уншигчийн картын орлогыг бэлнээр аваад ажлын дараагийн өдөрт багтаан төрийн сангийн дансанд тушаадаггүй, нэг удаа кассаар гаргах мөнгөн дүнгээс илүү дүнгээр зарлага гаргадаг, кассын тайлан, мөнгөн урьдчилгааны тайлан гаргадаггүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид кассын болон мөнгөн урьдчилгааны тайлан гаргаж байх.

4. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цэсэнд 2022 онд мэдээлбэл зохих 167 мэдээллээс 11 мэдээлэл хугацаа хоцроосон, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 9 шийдвэрийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулбал зохих мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд, тухай бүр мэдээлж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээлли йг тусгахгүй орхигдуул сан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаа гүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хууль тогтоомжи йн хэрэгжилт тэй холбоотой алдаа	1	34,080.5			1	34,080.5	1	34,080.5				
Дүн	1	34,080.5			1	34,080.5	1	34,080.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Худалдан авалт цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй.	4	12,490.0					4	12,490.0				
Дүн	4	12,490.0					4	12,490.0				